



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 12 өдөр

Дугаар A/351

Мөрөн сум

Г Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, хуулийн этгээд "Хөвсгөл трейвэл" ХХК /РД:2626993/-ийн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/61 дүгээр захирамжийн хавсралтын 3 дахь хэсэг Мөрөн 8 дугаар баг Согоот-2, 208 тоотод байршилтай 6712016103 нэгж талбарын дугаартай 2188 м² үйлчилгээтэй орон сууцны зориулалттай газар, аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/232 дугаар захирамжийн хавсралтын 12 дахь хэсэг Мөрөн 8 дугаар баг Согоот-2, 216 тоотод байршилтай 6712017312 нэгж талбарын дугаартай 882м² үйлчилгээтэй орон сууцны зориулалт бүхий 2 нэгж талбариудын газруудыг нэгтгэж газрын талбайн хэмжээг 3070 м² гэж өөрчилж үлдсэн 28 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/61 дүгээр захирамжийн хавсралтын 3 дахь хэсэг, 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/232 дугаар захирамжийн хавсралтын 12 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

3. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа хуулийн этгээд "Хөвсгөл трейвэл" ХХК /РД:2626993/-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүүл)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдеж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН